

**НИЙТИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ХЭЛТСИЙН ДАРХЛААЖУУЛАЛТ БОЛОН
ДАРХЛААЖУУЛАЛТ БҮХИЙ ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ХЯНАЛТ, СЭРГИЙЛЭЛТИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН Б.МӨНХЗУЛЫН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
Зорилт 1. “Зонхилон тохиолдох халдварт өвчний хяналт, сэргийлэлт, хариу арга хэмжээний бодлогын хэрэгжилт, зохицуулалт” зорилтын хүрээнд:							
1.1.	ЗГҮАХ 2.1.1.2 МУХТЖҮЧ 2.2.2 МУХТ 1.3.1 ЭМССТ 1.14 "Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх" арга хэмжээг хэрэгжүүлэх	Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь	Арга хэмжээний хэрэгжилт 70 хувьд хүрсэн.	2024 онд төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 80 хувьд хүрсэн байна.	Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/528 дугаар тушаалаар “Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх” арга хэмжээний төлөвлөгөөг 2022-2025 онд хэрэгжүүлэхээр баталж, 2024 онд 8 зорилтын хүрээнд 154 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ба хэрэгжилт 72 хувь байна. Арга хэмжээний төлөвлөгөөний Зорилт 2. болох “Дархлаажуулалтын хууль эрх зүйн орчныг шинэчилж, анхан шатны тусламж үйлчилгээнд тулгуурласан дархлаажуулалтын үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангаж, хэнийг ч орхигдуулахгүйгээр хамруулах боломжийг бүрдүүлэх” хүрээнд 20 арга хэмжээ төлөвлөснөөс хэрэгжилт 84% байна.	2024.01.01-2024.12.31	100%
1.2	ЗГҮАХ 1.1.3.5 МУХТЖҮЧ 2.2.1 МУХТ 1.1.3.5	Мэдээллээр хангаж	-	Ажлын хэсгийн гишүүд, удирдлагуудыг	Өвчний хяналт сэргийлэлтийн төвийн бүтэцэд 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр, дүрмийн төсөлд 2024 оны 04 дүгээр	2024.01.01-2024.12.31	0%

93

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
	ЭМССТ 1.3 Өвчний хяналт, сэргийлэлтийн төв байгуулах ажлын хэсэгт ажиллах	ажилласан тоо		холбогдох чиг үүргийн хүрээнд мэдээллээр хангасан байна.	сарын 17-ны өдөр бичгээр санал өгч, мэдээллээр хангаж ажилласан.		
1.3	Олон улсын эрүүл мэндийн дүрмийн 2 дах удаагийн хөндлөнгийн хамтарсан үнэлгээний зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулж, батлуулах	Батлагдсан шийдвэр	Олон улсын эрүүл мэндийн дүрмийн 2017 оны хөндлөнгийн хамтарсан үнэлгээ	Хөндлөнгийн хамтарсан үнэлгээний зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажилласан байна.	Олон улсын эрүүл мэндийн дүрмийн Хөндлөнгийн хамтарсан үнэлгээгээр ерөнхий 3 зөвлөмж хүргүүлсэн. Үүний нэг нь Нийгмийн эрүүл мэндийн аюулгүй байдлын үндэсний стратеги төлөвлөгөө боловсруулах бөгөөд энэ хүрээнд ТНБД-ын 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 2/2322, 2/2323, 2/2324, 2/2325, 2/2326 тоот стратеги төлөвлөгөө боловсруулах "Ажлын хэсэгт нэр ирүүлэх тухай" албан бичгүүдийг ЭМЯ, ХХААХҮЯ, БШУЯ, БОАЖЯ, ЦХХХЯ, ТЕГ, ОБЕГ, ЦЕГ, ГЕГ-т тус тус хүргүүлсэн. Нийгмийн эрүүл мэндийн аюулгүй байдлын үндэсний стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлалыг танилцуулах сургалт, хэлэлцүүлгийг 2024 оны 06 дугаар сарын 12-13-ны өдрүүдэд Улаанбаатар хотод дээрх байгууллагуудыг холбогдох албан тушаалтнуудыг оролцуулан зохион байгуулсан. Энэхүү сургалт, хэлэлцүүлэгт ДЭМБ-ын Төв оффис болон ДЭМБ-ын НДББ-ийн мэргэжилтнүүд ирж, төлөвлөгөө боловсруулах аргачлалыг танилцуулан, цаашид төлөвлөгөө боловсруулахад хэрэгжүүлэх алхмууд болон хугацааг тодорхойлсон. Энэхүү стратеги	2024.01.01-2024.12.31	50%

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
					төлөвлөгөө нь ОУЭМД-ийн Хөндлөнгийн хамтарсан үнэлгээний 19 техникийн чиглэлийн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх зорилготой юм. Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн шинэчлэн батлагдсантай холбогдуулан үйл ажиллагаа хойшлогдсон.		
Зорилт 2. “Дархлаажуулалт болон дархлаажуулалт бүхий халдварт өвчний хяналт, сэргийлэлтийн бодлогын хэрэгжилт, зохицуулалт” зорилтын хүрээнд							
2.1	ЗГҮАХ 1.1.2.4 Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийг улирлын томуугийн вакцинд хамруулах	Вакцинжуулалтад хамрагдалтын хувь	2023 онд вакцинжуулалтын хамралтын хувь 92% байсан.	Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийн 80%-аас доошгүй хувийг улирлын томуугийн вакцинжуулалтад бүрэн хамруулсан байна.	Томуугийн вакцин худалдан авахад шаардлагатай төсвийн хуваарийг Эрүүл мэндийн сайдын 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А/23 дугаар тушаалаар баталсан ба НҮБ-ын Хүүхдийн санд 5,6 тэрбум төгрөгөөр 300,000 хүн тун томуугийн вакциныг худалдан авах захиалгыг баталгаажуулсан. Эрүүл мэндийн сайдын 2024 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн А/359 дүгээр тушаалын дагуу 2024/2025 оны улирлын томуугийн эсрэг дархлаажуулалтыг 2024 оны 08 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн эрсдэлт бүлгийн хүн амын дунд зохион байгуулж, 2024 оны 12 дугаар сарын 06 өдрийн байдлаар улсын хэмжээнд зорилтот бүлгийн томуугийн вакцины хамралтын хувь 93.6%, үүнээс 0-5 насны хүүхдүүдийн хамралтын хувь 89.1% байна.	2024.01.01-2024.12.31	100%
2.2	МУХТЖҮЧ-2.2.1 ЭМССТ 1.20 Товлолт дархлаажуулалтад	Хүний папиллома вирусийн эсрэг	Засгийн Газрын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн	Хүний папиллома вирусийн эсрэг дархлаажуулалтад хамрагдсан 11	Хүний папиллома вирусийн эсрэг вакцинаар товллын дагуу дархлаажуулах ажлын хүрээнд Эрүүл мэндийн сайдын 2023 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн	2024.01.01-2024.12.31	50%

22

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
	хүний папиллома вирусийн эсрэг вакцин нэвтрүүлэх.	дархлаажуулалтад хамрагдсан 11 насны хүүхдийн эзлэх хувь	472 дугаар тогтоолоор "Заавал хийх дархлаажуулалтын үндэсний товлал"-ыг баталсан.	насны хүүхдийн эзлэх хувь 75 хувьд хүрсэн байна.	"Төсвийн хуваарь батлах тухай" А/69 дүгээр тушаалын хавсралтаар баталсаны дагуу тус вакцины 90,000 хүн тунг НҮБ-ын Хүүхдийн сангаар дамжуулан худалдан авч, Эрүүл мэндийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/475 дугаар тушаалаар орлогод авсан. Эрүүл мэндийн сайдын 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн "Төсвийн хуваарь батлах тухай" А/23 дугаар тушаалаар Хүний папиллома вирусийн эсрэг 30,000 хүн тун вакциныг нэмэлтээр худалдан авах төсвийг баталсан. Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/32 дугаар тушаалаар хүний папиллома вирусын эсрэг вакциныг дархлаажуулалтад нэвтрүүлэх нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ажлын хэсгийн удирдамжийг, хүний папиллома вирусийн халдварын эсрэг вакцинаар дархлаажуулах 2024-2025 оны төлөвлөгөөг Эрүүл мэндийн сайдаар батлуулан хэрэгжүүлж байна. Вакцин дархлаажуулалтын глобаль альянс байгууллагын техникийн дэмжлэгийн хүрээнд: - "Хүний папиллома вирусийн халдвар, ХПВ-ийн халдварын эсрэг вакцины талаарх мэдлэг, хандлага, дадлын судалгаа"-г АШУУИС-ийн НЭМС-тай хамтран НҮБ-ын Хүүхдийн сангийн		

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
					дэмжлэгтэйгээр 5 аймаг, 2 дүүргийн нутаг дэвсгэрт байрлах ЕБС-ийн багш, сурган хүмүүжүүлэгч, эцэг эхчүүд болон эрүүл мэндийн байгууллагын эмч, ажилтнууд 3000 хүнийг хамруулан хийсэн. - ЭМЯ-ны яамны мэргэжлийн салбар зөвлөл, эрүүл мэндийн ажилтан, ЕБС-ийн захирал, багш, эмч, нийгмийн ажилтан, хэвлэл мэдээллийн ажилтан болон шийдвэр гаргах түвшний нийт 5040 хүнийг сургалтад хамруулсан. - НЭМҮТ-ийн мэдээллийн 119 тусгай дугаарын 12 ажилтныг сургаж, иргэдийг мэдээллээр хангаж байна. - НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран нийт 8 төрлийн 212,600 ширхэг сурталчилгааны материал түгээгээд байна. -Эрүүл мэндийн сайдын 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн “Хүний папиллома вирусийн халдварын эсрэг вакцинаар дархлаажуулах тухай” А/455 дугаар тушаалын дагуу товллын насны хүүхдүүдийг 11 дүгээр сарын 28-ны өдрөөс эхлэн дархлаажуулж эхэлсэн ба 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар дархлаажуулалтын хамралт 20% байна.		
2.3	МУХТЖҮЧ-2.2.1 ЭМССТ 1.16 Шуурхай удирдлагын нэгж байгуулах	Байгуулагдсан шуурхай удирдлагын нэгжийн тоо	4 аймаг, 4 байгууллагад Шуурхай удирдлагын нэгж байгуулсан.	Шуурхай удирдлагын нэгжийг байгуулсан байна. 3	Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хууль батлагдсантай холбоотойгоор Нийгмийн эрүүл мэндийн асуудал хариуцсан үндэсний төв байгууллага болон аймаг, дүүрэгт байгуулах НЭМТ-ийн бүтэцэд ШУН	2024.01.01- 2024.12.31	0%

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
					байхаар хуульчлагдсан тул түр хойшилсон.		
2.4	Эрүүл мэндийн сайдын 1997 оны "Журам батлах тухай" А/219 дүгээр тушаал шинэчлэн батлуулах	Эрүүл мэндийн сайдын тушаал	Эрүүл мэндийн сайдын 1997 оны А/219 дүгээр тушаалыг мөрдөж ажиллаж байна.	Эрүүл мэндийн сайдын тушаал шинэчлэгдэн батлагдсан байна.	"Вакцин, биобэлдмэлийг төлөвлөх, захиалах, зарцуулах, ханган нийлүүлэх журам" болон "Вакцин, биобэлдмэлийг хүлээн авах, хадгалах, тээвэрлэх явцад баримтлах журам"-ыг боловсруулсан.	2024.01.01-2024.12.31	50%
2.5	Тарилгатай халдварт өвчний тандалтын тогтолцоог үнэлэх	Үнэлгээний тайлан, зөвлөмж	-	Үнэлгээ хийгдэж, тайлан зөвлөмж гарсан байна.	Тарилгатай халдварт өвчний тандалын тогтолцооны үнэлгээг 2024 оны 03 дугаар сарын 18-29 өдрүүдэд ДЭМБ-ын НДББ-ийн мэргэжилтнүүдтэй хамтран гүйцэтгэсэн бөгөөд үнэлгээний хүрээнд Архангай, Төв аймаг болон нийслэлийн Сонгинохайрхан, Чингэлтэй дүүргүүдийн НЭ, ЭМТ-ийн холбогдох эмч, мэргэжилтнүүдтэй уулзаж, мэдээлэл цуглуулсан. Үнэлгээний тайлан, зөвлөмжийг ДЭМБ-ын НДББ-ийн мэргэжилтнүүдтэй хамтран хянаж, эцэслэн хүлээн авсан.	2024.04.01-2024.05.31	100%
2.6	Талбарын тархвар судлал (ТТС)-ын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх	Батлагдсан шийдвэр	Талбарын тархвар судлалын 2016-2018 оны хөгжлийн төлөвлөгөө	Талбарын тархвар судлал (ТТС)-ын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө батлагдсан байна.	Талбарын тархвар судлал (ТТС)-ын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөөг боловсруулж, Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулахаар газар хэлтсийн дарга нарт тойрох хуудсаар танилцуулсан. ТЗУГ-аас ЭМС-ын тушаалаар батлуулах шаардлагагүй гэсэн санал өгсөн тул Халдварт өвчин судлалын үндэсний төвийн стратеги төлөвлөгөөнд нэг зорилт болгон тусгаж, хяналтын шатандаа явж байна.	2024.01.02-2024.06.30	50%

Д/д	Зорилтын хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
2.7	Вакцин, биобэлдмэл, зүү тариурын ханган нийлүүлэлтийн ажлыг зохион байгуулах	Эрүүл мэндийн сайдын тушаал	Эрүүл мэндийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/475 дугаар тушаал "Вакцин, биобэлдмэл, дагалдах хэрэгслийг орлогод авах тухай"	Вакцин, биобэлдмэл, зүү тариурын захиалга хийж, хангалт хийгдсэн байна.	Эрүүл мэндийн сайдын 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А/23 тоот тушаалаар вакцин, биобэлдмэл худалдан авах төсвийн хуваарийг баталсан ба заавал хийх үндэсний товллын болон тархвар судлалын заалтаар хийгдэх шаардлагатай вакцин, биобэлдмэлийн захиалгуудыг НҮБ-ын Хүүхдийн санд хүргүүлж, мөн дотоодын ханган нийлүүлэгчээр худалдан авах ажиллагааг зохион байгуулж байна. ХӨСҮТ-ийн Вакцин, биобэлдмэлийн төв агуулахад 21 төрлийн 1,387,384 гаруй хүн тун вакциныг хүлээн авсан.	2024.01.01-2024.12.31	100%
Зорилт 3. "Нийтийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээ, эрсдэлийн удирдлага, хариу арга хэмжээний бодлогын хэрэгжилтийн зохицуулалт" зорилтын хүрээнд:							
3.1	"Монгол Улсын цартахлаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдал, хариу арга хэмжээ авах чадавхыг Нэг эрүүл мэнд зарчимд тулгуурлан бэхжүүлэх" төслийн хэрэгжилтийг хангах	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	2023 онд төсөл батлагдсан.	Төслийн удирдах хороо, техникийн ажлын хэсэг байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөө батлуулсан байна.	Эрүүл мэндийн сайдын 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн А/85 тоот тушаалаар "Цартахлаас сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг хэрэгжүүлэх Монгол Улсын чадавхыг нэг эрүүл мэнд зарчимд тулгуурлан бэхжүүлэх" төслийн Удирдах хороо, техникийн ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсан ба техникийн ажлын хэсгийн хурлыг 2 удаа зохион байгуулсан. Төслийг хэрэгжүүлэх 2024-2026 оны ерөнхий төлөвлөгөөг Төрийн нарийн бичгийн даргаар 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр батлуулсан. Төслийн хүрээнд 2024 онд ЭЭХХЗГ-ын Эм шинжлэх лабораторийн хүчин чадлыг сайжруулах, ЭМЯ-ны ШУТ-ийн өрөө	2024.01.01-2024.12.31	100%

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
					тасалгааг засварлах, тоног төхөөрөмжөөр хангах зэрэг томоохон ажлууд хийгдэж байна. Төсөл хэрэгжүүлэгч байгууллагууд болох ДЭМБ, НҮБ-ын Хүүхдийн сангийн төлөөллүүд Эрүүл мэндийн сайд болон холбогдох газар, хэлтсийн дарга нартай 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр уулзаж төслийн явцтай танилцан, ЭМЯ-ны бүтэц, бүрэлдэхүүн шинэчлэгдсэнтэй холбогдуулан төслийн удирдах хороог шинэчлэн батлахаар болсон.		
3.2	Биотерроризм болон биологийн зэвсгийн аюулаас урьдчилан сэргийлэх салбар хоорондын хамтын ажиллагааг зохицуулах	Зохион байгуулагдсан хурал, хэлэлцүүлэгт хамрагдсан тоо	-	Терроризмтой тэмцэх зөвлөл болон холбогдох байгууллагуудаас зохион байгуулсан хурал, зөвлөгөөнд оролцож, санал зөвлөмж хүргүүлсэн байна.	АСЕАН-ы Бүс нутгийн чуулга уулзалтын хүрээнд АСЕАН-ын Нарийн бичгийн дарга нарын газар, АНУ-ын Төрийн Департамент, Вьетнамын Гадаад харилцааны яам болон манай улсын Гадаад харилцааны яамнаас хамтран зохион байгуулсан "Хими, биологи, цөмийн болон цацрагийн терроризмын эсрэг хууль эрх зүйн тогтолцооны хэрэгжилтийг бэхжүүлэх" асуудлаарх сургалт, семинарт 2024 оны 04 дүгээр сарын 16-18-ны өдрүүдэд оролцож, санал солилцсон. Бактериологийн (биологийн) болон токсины зэвсэг боловсруулах, үйлдвэрлэх, нөөцлөхийг хориглох, тэдгээрийг устгах тухай" конвенцийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлж Итгэл бэхжүүлэх арга хэмжээний 2023 оны тайланд тусгах салбарын холбогдох мэдээллийг Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 02 дугаар	2024.01.01-2024.12.31	100%

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
					сарын 20-ны өдрийн 2/701 тоот албан бичгээр Гадаад харилцааны яаманд хүргүүлсэн.		

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1.	Сүрьеэгээс сэргийлэх, хянах арга хэмжээний төлөвлөгөө (2024-2026) боловсруулж батлуулах	Эрүүл мэндийн сайдын тушаал	Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээний 2022-2025 оны төлөвлөгөөний зорилт 3	Төлөвлөгөөг боловсруулж, батлуулсан байна.	Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/537 дугаар тушаалаар байгуулагдсан "Сүрьеэ өвчний эсрэг цогц арга хэмжээний өргөтгөсөн төлөвлөгөө боловсруулах" ажлын хэсгийг төлөвлөгөөний төслийг эцэслэн боловсруулж, ЭМЯ-ны газар, хэлтсийн дарга нараар хянуулсан. "Өр хөрвүүлэх" хөтөлбөрийн 2025-2026 онд хэрэгжих үйл ажиллагаатай холбогдуулан БЗДХ, ХДХВ, ДОХ-оос сэргийлэх, хянах арга хэмжээний төлөвлөгөөг дахин шинэчлэх шаардлага бий болсон.	2024.01.01-2024.12.31	70%
2.	Бүгд Найрамдах Солонгос Улсын буцалтгүй тусламжийн хүрээнд хэрэгжих "Монгол Улсын халдварт өвчний хяналтын тогтолцоог бэхжүүлэх төсөл"-ийн хэрэгжилтийг хангаж ажиллах	Төслийн тайлан	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны 9 дүгээр тэмдэглэл 2024-03-06 Дугаар 2024_9	Төслийн зохицуулах багийг томилж, төслийн үйл ажиллагаан эхэлсэн байна.	"Монгол Улс дахь Халдварт өвчний нийгмийн эрүүл мэндийн бэлэн байдал, хариу арга хэмжээний чадавхийг бэхжүүлэх төсөл"-ийг БНСУ-ын ЗГ-ын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр Солонгосын Өвчний хяналт сэргийлэлтийн агентлагтай хамтран үндэсний болон орон нутгийн хэмжээнд 2023-2027 онд хэрэгжүүлэхээр болсон. Төслийн зохицуулах багийн ХӨСҮТ-ийн	2024.01.01-2024.12.31	100%

253

				Ерөнхий захирлын 2024.06.04-ний өдрийн А/55 дугаар тушаалаар баталсан. Төслийн хүрээнд 2024 онд ХӨСҮТ-ийн BSL3 лабораторит үнэлгээ дүгнэлт хийлгэн зөвлөгөө өгч, Нэгдсэн лабораторит Vitek2 Compact тоног төхөөрөмжийг шинээр суурилуулсан. Ёнсэй их сургуулийн эрүүл мэндийн төвийн эксперт, мэргэжилтнүүд ХӨСҮТ-д 2024 оны 09 дүгээр сарын 04-05-ны өдөр эрдэм шинжилгээний симпозиум зохион байгуулсан. Талбарын тархвар судлаачдад зориулсан тохиолдолд суурилсан сургалтыг БНСУ-ын Өвчний хяналт, сэргийлэлтийн агентлагаас 2024 оны 09 дүгээр сарын 23-24-ний өдөр зохион байгуулж, “Усаар дамжих халдвар болон MERS-ийн халдварын дэгдэлт”-ийн тархвар судлалын сургагч багш нарыг бэлдсэн. ХӨСҮТ-ийн Нян судлалын лабораторид Микробанк өсгөвөр хадгалах сав 11 багц буюу 891 ширхгийг хүлээн авсан. Төслийн хүрээнд 139,700,000 вонын үнэ бүхий SENSITITRE NEPHELOMETER аппарат болон 249,000 ам.доллар үнэ бүхий 16000 гаруй үүсгэгчийг молекул биологийн аргаар богино хугацаанд тодорхойлох хүчин чадалтай IVD MALDI Biotyper Sirius One System аппаратуудыг ХӨСҮТ-д хүлээлгэн өгөхөөр гаалийн бүрдүүлэлтийг хийж байна. ХӨСҮТ-ийн Нян судлалын лабораторийн 5 мэргэжилтэн 2024 оны 11 дүгээр сарын 3-26-ны өдрүүдэд БНСУ-ын Ёнсэй Их Сургууль, Өвчний хяналт сэргийлэлтийн төвд нян судлалын чиглэлээр богино	
--	--	--	--	--	--

					хугацааны сургалтад хамрагдсан. ЭМЯ, ДЭМБ, Солонгосын Өвчний хяналт сэргийлэлтийн төв хамтран “Лабораторид суурилсан тандалтын тогтолцоог бэхжүүлэх” олон улсын форумыг 2025 оны 02 дугаар сарын 24-нд 120 гаруй холбогдох албан тушаалтнуудын оролцуулан зохион байгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Шувууны томуугийн шинэ вируст хүний халдвар бүртгэгдсэн үед хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах, шуурхай зохион байгуулах чадавхыг сайжруулах зорилготойгоор үзүүлэх сургалтыг үндэсний түвшинд ЭМЯ, БШУЯ, БОАЖЯ, ХНХЯ, ЦХХХЯ, ОБЕГ, ХХЕГ, МЭАЦТЛ, МЭХ, БЕГ, ХӨСҮТ, ЗӨСҮТ, НЭМҮТ, ЭЭХХЗГ, ЭМЯ-ны харъяа лавлагаа шатлалтын төвүүдийг, орон нутгийн түвшинд аймаг, нийслэлийн ЭМГ, НЗДТГ, дүүргийн ЭМТ, өрхийн ЭМТ, сумын ЭМТ болон бусад салбар байгууллагуудыг оролцуулан 5 бүсэд хуваан 2025 оны 2-4 улиралд хийхээр төлөвлөн ажиллаж байна.		
3.	УОК-ын 2024 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн 05 дугаар хурлын тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх	Хариу арга хэмжээний төлөвлөгөө, тайлан	-	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг УОК-ийн ажлын албанд хүргүүлсэн байна.	-Улаанбурханы зөөвөрлөгдсөн тохиолдол бүртгэгдсэнтэй холбогдуулан ЭМС-ын 2024 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн А/342 дугаар “Шуурхай удирдлагын баг томилох тухай” тушаалыг боловсруулан батлуулж, шуурхай хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэн ЭМС-ын 2024 оны 8 дугаар сарын 7-ны өдрийн А/344 тоот “Улаанбурхан өвчний дэгдэлтийн үеийн дархлаажуулалтыг зохион байгуулах тухай” тушаал, Улаанбурханы дэгдэлтийн үед ажиллах Эрүүл мэндийн улсын	2024.01.01-2024.12.31	100%

					албаны үйл ажиллагааны төлөвлөгөөг тус тус боловсруулж батлуулан хэрэгжүүлж ажилласан. УОК-ын даргын 2024 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн 07 дугаар тушаалын дагуу Шуурхай бүлэгт томилогдон ажилласан. -ТТӨ-ний дэгдэлтийн үед ажиллах ТУТ-ны багийг томилох тухай тушаалыг боловсруулан ЭМС-ын 2024 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн А/437 дугаар тушаалаар батлуулан, ТУТ-ны багт орж ажиллаж байна. ЭМЯ-ны Нийгмийн эрүүл мэндийн үйл явдлын долоо хоног тутмын мэдээг 2024 оны 07 дугаар сарын 15-аас 10 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл 7 хоног бүр нэгтэн ажилласан. УОК-ын 05 дугаар хурлын тэмдэглэлийн дагуу 7 арга хэмжээний хэрэгжилтийн тайланг 2024.08.21-ний өдрийн 2/3430 албан тоотоор УОК-ын нарийн бичгий даргад хүргүүлсэн.		
4.	Эрүүл мэндийн сайдаас өгсөн үүрэг даалгаврын дагуу Томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үед ажиллах Тохиолдлын удирдлагын тогтолцооны багийг байгуулах	Эрүүл мэндийн сайдын тушаал	-	Эрүүл мэндийн сайдын тушаал батлагдаж гарсан байна.	Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэх Тохиолдлын удирдлагын багийн бүрэлдэхүү, чиг үүргийг боловсруулж, ЭМС-ын 2024 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн А/437 дугаар тушаалаар батлуулсан.	2024.07.15-2024.12.31	100%
5.	Сургуульд суурилсан дархлаажуулалтын эрх зүйн орчинг сайжруулах	ЭМС, БС-ын хамтарсан тушаал	-	ЭМС, БС-ын хамтарсан тушаал батлагдсан байна.	Боловсролын сургалтын байгууллагад суурилсан дархлаажуулалтын зохион байгуулалт, цэгийн бэлэн байдлыг хангах зааврыг боловсруулж, ЭМС, БС-ын 2024 оны 12 дугаар сарын 05-	2024.07.15-2024.12.31	100%

					ны өдрийн А/484, А/231 дугаар тушаалаар батлуулсан.		
6.	ХПВ-ийн халдварын эсрэг дархлаажуулалтыг нэвтрүүлэхэд техникийн дэмжлэг үзүүлэх төсөл боловсруулж, батлуулах				2024 оны 04 дүгээр сарын 16-18-ны өдрүүдэд Вакцин дархлаажуулалтын глобаль альянс байгууллагын төлөөллүүдийг хүлээн авч, ХПВ-ийн вакцин нэвтрүүлэхэд техникийн дэмжлэг үзүүлэх төслийг боловсруулахад анхаарах асуудлаар ДЭМБ, НҮБ-ын Хүүхдийн сан, НҮБ-ын Хүн амын сантай хамтарсан уулзалтыг зохион байгуулсан. ХПВ-ийн вакцин нэвтрүүлэхэд техникийн дэмжлэг үзүүлэх нийт 2,8 сая ам.долларын төсөвтэй төслийг боловсруулж, 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдөр Вакцин дархлаажуулалтын глобаль альянс байгууллагад хүргүүлсэн. Тус байгууллагаас ХПВ-ийн эсрэг вакцин нэвтрүүлэхэд 2.6 сая ам.долларын техникийн дэмжлэгийг ДЭМБ, НҮБ-ын Хүүхдийн сангаар дамжуулан үзүүлэх болсоноо 2024 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн албан захиагаар мэдэгдсэн.	2024.07.15-2024.12.31	100%
7.	ЗГҮАХ 1.1.3.3 МУХТЖҮЧ 2.2.2 Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвараас сэргийлэх мэдээлэл, сургалт, сурталчилгаа зохион байгуулах	Мэдээлэл, сургалт, сурталчилгаа ны тоо	Халдварт өвчнөөс сэргийлэх чиглэлээр 1060 инфографик, 58 хөдөлгөөнт шторк, 46 цуврал контент, 260 текстэн зөвлөгөө	Сургалт сурталчилгааны төлөвлөгөөг батлуулсан байна	Шинэ болон сэргэн тархаж буй халдварт өвчний мэдээлэл, сурталчилгааны ажлын 2024 оны нэгдсэн төлөвлөгөөг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр Дэд сайдаар батлуулж, 6/1362 дугаар албан бичгээр НЭМҮТ, ХӨСҮТ, ЗӨСҮТ-д хүргүүлсэн. Зудтай холбоотой үүсэх эрүүл мэндийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сурталчилгааны төлөвлөгөөг 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдөр	2024.01.01-2024.12.31	100%

			бэлтгэн Эрүүл мэндийн яамны фэйсбүүк хуудсанд байршуулан давхардсан тоогоор 1.3 сая иргэнд мэдээлэл хүргэсэн.		Эрүүл мэндийн Дэд сайдаар батлуулан хэрэгжүүлсэн. Халдварт өвчнөөс сэргийлэх чиглэлээр Дэлхийн банкт хамтран гарын эрүүл ахуйн чиглэлээр 4880, ЭМБ-ын хог хаягдлын талаар 2440, Халдварын дамжих замд суурилсан сэргийлэлтээр 2440, ЭМБ-ын цэвэрлэгээ, үйлчилгээний чиглэлээр 2440, цусаар дамжих халдварын чиглэлээр 2440 ширхэн постер хэвлүүлж, 21 аймаг, 9 дүүрэг, ЭМЯ-ны харьяа байгууллагуудад түгээсэн.		
8.	ЗГҮАХ 2.1.1.5 МУХТЖҮЧ 2.2.1 “Элэг бүтэн Монгол” арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх	Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь	Арга хэмжээний хэрэгжилт 70% хүрсэн.	Арга хэмжээнд тусгагдсан үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байна.	Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/577 дугаар тушаалаар батлагдсан “Элэг бүтэн Монгол” арга хэмжээний төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 34 арга хэмжээг төлөвлөн 2022-2025 онд хэрэгжүүлж байна. Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 63 хувьтай байна.	2024.01.01-2024.12.31	90%
9.	Сүрьеэтэй тэмцэх алба үүсэж, хөгжсөний 100 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулах	Ойн арга хэмжээг зохион байгуулсан байна.	Сүрьеэтэй тэмцэх алба үүсэж, хөгжсөний 80 жилийн ойн арга хэмжээ	Ойн арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулж, үйл ажиллагааны удирдамж, төлөвлөгөөг батлуулсан байна.	Ойн арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулж, төлөвлөгөө батлах тухай ХӨСҮТ-ийн захирлын 2024 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн А/56 тоот тушаалаар батлагдсан. “Сүрьеэ судлалын салбар үүсэж хөгжсөн 100 жилийн түүхэн товчоон”, “Сүрьеэ судлалын эмч, мэргэжилтний алдар суу”, “100 чухал үйл явдал” 3 боть ном хэвлүүлж, 100 жилийн баримтат кино хийссэн. Ойн арга хэмжээг 2024 оны 11 дүгээр сард Улаанбаатар хотод зохион байгуулсан.	2024.01.01-2024.12.31	100%
10.	Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын хариу арга хэмжээний чиглэлээр	Хамтарсан дасгал сургуулилт	2022 онд дасгал сургуулилт хийгдсэн.	Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын хариу арга хэмжээний чиглэлээр	- Улаанбаатар хот, Хөвсгөл, Говь-Алтай, Дорноговь аймгуудад салбар хоорондын байгууллагын мэргэжилтнүүдийг оролцуулсан “Нийгмийн эрүүл мэндийн ноцтой	2024.01.01-2024.12.31	100%

	хамтарсан дасгал, сургуулилт хийх			хамтарсан дасгал, сургуулилт хийх төлөвлөгөөг боловсруулж, батлуулсан байна.	байдал, болзошгүй цартахлын бэлэн байдал, хариу арга хэмжээ” сэдэвт бүсчилсэн ширээний дасгал сургуулилтыг 2024 оны 08 дугаар 23-аас 9 дүгээр сарын 14-ны хугацаанд зохион байгуулсан. ”Вектороор дамжих халдварт өвчин”-ий чиглэлээр 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр НДББ-ийн БНСУ, БНХАУ, Сингапур, Малайз, Камбожи, Вьетнам, Хонконг, Лаос, Макао, Филиппин зэрэг 17 улс оронтой манай улс амжилттай оролцлоо. Энэ дасгал сургуулилтад салбар хоорондын оролцоог хангаж, ЗӨСҮТ, ОБЕГ, Мал эмнэлгийн ерөнхий газар, Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн нийт 20 гаруй мэргэжилтнүүд оролцон, ОУЭМД-ийн үндэсний зохицуулагч (ХӨСҮТ)-ийн харилцаа холбооны бэлэн байдлыг утсаар болон цахимаар амжилттай шалгууллаа.		
11.	“Нэг эрүүл мэнд” салбар хоорондын үйл ажиллагааг өргөжүүлэх	Хамтарсан зөвлөлдөх уулзалт зохион байгуулах	-	Хамтарсан зөвлөлдөх уулзалт зохион байгуулсан байна.	- ХХААХҮЯ, БОУАӨЯ, ДЭМБ, ДХХААБ, Нэгдсэн үндсэний орчны хөтөлбөр, Дэлхийн амьтны эрүүл мэндийн байгууллагатай хамтран Монгол Улсын “Нэг Эрүүл мэнд”-ийн зарчмыг хэрэгжүүлэх арга хэмжээний хамтарсан төлөвлөгөө” боловсруулах уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан. Эрүүл мэндийн тогтолцооны чадавх, НЭМ-ийн ноцтой байдал, цартахал үүсгэж болох шинэ болон сэргэж буй зоонозын халдварт өвчний эрсдэл, нутагшмал зоонозын өвчнийг хор нөлөө, хүнсний аюулгүй байдлын эрсдэл, чимээгүй цартахал буюу бичил биетний тэсвэржилт,	2024.01.01-2024.12.31	100%

2025

					байгаль орчин, хүрээлэн буй орчны эрсдэл гэсэн үндсэн 6 асуудлыг цогцоор нь авч хэлэлцсэн. - "Сүрьеэ болон ям өвчний хяналт төсөл" САТРЕПС төслийн хүрээнд Эрүүл мэндийн яам, Халдварт өвчин судлалын үндэсний төв, Мал эмнэлгийн хүрээлэн, Япон Улсын Хоккайдогийн их сургууль, Япон Улсын сүрьеэ судлалын хүрээлэн хамтран хэрэгжүүлж ирсэн бөгөөд Монгол Улсын Боловсрол, соёл шинжлэх ухааны яам, Сангийн яам, Мал эмнэлгийн ерөнхий газар, Зоонозын өвчин судлалын үндэсний төв уг төслийг дэмжин, хамтран ажиллаж байна. Уг төслийн хүрээнд биоаюулгүй 3-р зэрэглэлийн лаборатори байгуулах, эрдэм шинжилгээний баг хурал зохион байгуулах, Төслийн зохицуулах хорооны 3 дугаар хурлын зохион байгуулсан.		
12.	"Нийгмийн эрүүл мэндийн бодлого тэргүүлэх чиглэл болох нь" эрүүл мэндийн салбарын удирдах ажилтны зөвлөгөөн зохион байгуулах	Зөвлөгөөний хөтөлбөр, тайлан	-	Зөвлөгөөний хөтөлбөр батлагдаж, хамтран зохион байгуулан, тайлан гарсан байна.	"Нийгмийн эрүүл мэндийн бодлого тэргүүлэх чиглэл болох нь" эрүүл мэндийн салбарын удирдах ажилтны зөвлөгөөний хөтөлбөрийг Эрүүл мэндийн сайдаар батлуулж, 2024 оны 10 дугаар сарын 17-ны өдөр Улаанбаатар хотод зохион байгуулсан. Зөвлөгөөнд УИХ-ын гишүүд, НҮБ-ын төрөлжсөн байгууллагын төлөөлөл болон бүх шатны эрүүл мэндийн байгууллагын удирдлагын төлөөлөл 1000 гаруй хүн оролцсон.	2024.01.01-2024.12.31	100%
13.	Эмч долоодугаар нарын их хурлыг зохион байгуулах	Хурлын хөтөлбөр, тайлан, зөвлөмж	-	Хурлын хөтөлбөр батлагдаж, хамтран зохион	Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор эмч нарын долоодугаар их хурлыг 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдөр Төрийн ордонд зохион байгуулсан. Хуралд	2024.01.01-2024.12.31	100%

				байгуулан, тайлан гарсан байна.	Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-ын гишүүд, холбогдох яамдын сайд, Ерөнхийлөгчийн зөвлөх, аймаг, нийслэлийн төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад ажиллаж буй эмч, эмнэлгийн мэргэжилтэн, НҮБ-ын төрөлжсөн байгууллагын төлөөллүүд болох 850 гаруй хүн оролцсон.		
14.	Багийн эмч нарын зөвлөгөөн зохион байгуулах	Хурлын хөтөлбөр, тайлан, зөвлөмж	-	Хурлын хөтөлбөр батлагдаж, хамтран зохион байгуулан, тайлан гарсан байна.	Эрүүл мэндийн салбарын 7 хоногийн арга хэмжээний хүрээнд “Багийн эмч нарын зөвлөгөөн”-ийг 2024 оны 10 дугаар сарын 19-ний өдөр Төрийн ордонд зохион байгуулсан. Зөвлөгөөнд Монгол Улсын 330 сумын багийн эмч нарын төлөөлөл 700 гаруй хүн оролцсон.	2024.01.01-2024.12.31	100%

Хоёр. Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
1		2	3	4	5	6	7
1.	Төрийн албаны тухай хуулийн 24, 29.1 дүгээр зүйлд заасан Удирдлагын	Сургалтын гэрчилгээ	-	Богино хугацааны сургалтад сурсан байна	Удирдлагын академиас зохион байгуулдаг Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны зайн сургалтад 2024 оны 03 дугаар сарын 12-ны	2024.01.01-2024.12.31	100%

01/2

	академийн “Төрийн албан хаагчийн богино хугацааны сургалтын хөтөлбөр”-т хамрагдах				өдрөөс 04 дүгээр сарын 03-ны өдрийг хүртэл хугацаанд хамрагдаж, амжилттай дүүргэн гэрчилгээ авсан.		
2.	Халдварт өвчин, дархлаажуулалт болон нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын чиглэлээр сургалт, семинарт оролцох	Сургалтад хамрагдсан тоо	-	Холбогдох сургалтад хамрагдсан байна.	БОАЖЯ-ны Р87 төслийн хүрээнд Узбекистан Улсын Ташкент хотод 2024 оны 03 дугаар сарын 04-06-ны өдрүүдэд зохион байгуулсан “Нийтийг хамарсан үйл ажиллагаа болон бусад эрүүл мэндийн аюулын үеийн эрсдэлийн харилцаа холбоо” сэдэвт сургалтад оролцсон. ДЭМБ-ын НДББ-ээс Филиппин Улсын Манила хотод 2024 оны 03 дугаар сарын 12-14-ний өдрүүдэд зохион байгуулсан “Эрүүл мэндийн аюулгүй байдлын үндэсний стратег төлөвлөгөө боловсруулах” сургалтад оролцсон. ДЭМБ-ын Төв оффисд 2024 оны 09 дүгээр сарын 03-04-ний өдрүүдэд “Эрүүл мэндийн гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдал, хариу арга хэмжээ харуцсан Байнгын хорооны тав дахь удаагийн хурал”-д оролцсон.	2024.01.01-2024.12.31	100%
3.	Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр судалгааны ажил хамтран хийх	Судалгааны ажлын үр дүн, судалгааны тоо	-	Судалгааны ажлын тойм хийсэн байна.	Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Талбарын тархвар судлалын төрөлжсөн мэргэжлийн сургалтын суралцагч Г.Ган-Эрдэнийн “Монгол Улсад 2015-2022 онд бүртгэгдсэн сэргийлж болох нас баралтын түвшинг судлах нь” сэдэвт судалгааны удирдагчаар ажилласан. Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Талбарын тархвар судлалын анхан шатны сургалтын суралцагч А.Анударийн “Өмнөговь аймгийн Даланзадгад сумын 30-аас дээш насны эмэгтэйчүүдэд хүний папилома	2024.01.01-2024.12.31	100%

					вирусын хэв шинжийг тодорхойлох нь” сэдэвт судалгаанд удирдагчаар ажиллаж байна. Австралийн Их Сургуулийн докторант Маттью Гриффиттэй хамтран “Хэрэглээний (талбарын) эпидемиологийн сургалтад суралцах үйл явцыг судлах нь” сэдэвт судалгааны ажилд хамтарсан судлаачаар оролцож байна.		
--	--	--	--	--	---	--	--

ТАЙЛАН ГАРГАСАН:

Мэргэжилтэн
(Албан тушаал)

Б.Мөнхзул /  /
(Нэр, гарын үсэг)

2024.12.10
(Огноо)

